



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

“Багахангай лиг-2023” волейболын  
тэмцээн зохион байгуулах  
Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд “Багахангай лиг-2023” волейболын тэмцээнийг дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Б.Болормаа

Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч

Гишүүд:

Н.Батцэнгэл

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хяналт шинжилгээ, үнэлгээ, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн

Г.Тэмүүлэн

Биеийн тамир, спортын хорооны дарга

Б.Буянзаяа

Биеийн тамир спортын хорооны мэргэжилтэн

Б.Баярцогт

Хангай цогцолбор сургуулийн биеийн тамирын багш

Нарийн бичгийн  
дарга:

Ө.Амарзаяа

Нийгмийн хөгжлийн хэлтсийн хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Тэмцээнийг холбогдох хууль, журам, удирдамжийн дагуу чанар, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД